

## ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Төслийн товч тодорхойлолт .....	3
1.2. Төсөл хэрэгжих орчны газар ашиглалт, дэд бүтцийн хөгжил.....	10
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	12
3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....	15
3.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ.....	15
3.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	15
3.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл .....	15
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
5. НОГООН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТЭРБУМ МОД ХӨТӨЛБӨР	22
6. ХИМИЙН БОДИС ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	24
7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	25
8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	26
9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	27
10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	30
11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ.....	31

## **Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол	3
Хүснэгт 2. Төслийн газар эзэмших эрхийн талаар мэдээлэл	6
Хүснэгт 3. Химийн бодисын агуулахад хадгалагдах бодисын жагсаалт	9
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	18
Хүснэгт 5. Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө	22
Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	25
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	28
Хүснэгт 9. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	30
Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь	31
Хүснэгт 11. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт	32

## **Зургийн жагсаалт**

Зураг 1. Талбайн байршлын тойм зураг .....	4
Зураг 2. Химийн бодисын агуулах .....	4
Зураг 3. Агуулахад хадгалах бодисын төрөл.....	6
Зураг 4. Агуулахын гадна талбайн тохижилт, тэмдэг, тэмдэгжүүлсэн байдал .....	7
Зураг 5. Химийн бодис, пиротехникийн хэрэгслийн агуулахын дотор орчны харагдах байдал .....	8
Зураг 6. Үер усны хамгаалалтын шуудуу .....	11
Зураг 7. Харуулын байр, хашаа хамгаалалт.....	11
Зураг 9. Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд мод тарих газрын байршил, 2026 он .....	23
Зураг 10. Мониторингийн байршлын зураг.....	29

## 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн товч тодорхойлолт

**Төслийн нэр:** Химийн бодисын агуулах

**Төсөл хэрэгжүүлэгч:** “Алма Кем Трейд” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011879169, Регистрийн дугаар: 7155609

**Төсөл хэрэгжүүлэгч хаяг:** Улаанбаатар хот, Элчингийн гудамж 9, Скай плаза бизнес төв

Утас: 88042323

### Зорилго

Орчин үеийн шилдэг менежментийг компанидаа нэвтрүүлэн мэргэжлийн болон ёс зүйн өндөр чадвартай хамт олноор багаа бүрдүүлж Монгол улсын хэмжээнд хамгийн чанартай химийн бодисыг ААН-үүдэд нийлүүлэх.

### Товч танилцуулга

“Алма Кем Трейд” ХХК Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хороонд байрлах “Очир-Ундраа” ХХК-ийн “12х10 буюу 120 м.кв талбайтай Агуулах№2”-д химийн бодисын агуулахад, химийн бодис хадгалах, импорт, худалдах үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байна. Тус химийн бодис хадгалах агуулах нь “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 10 дугаар зүйлд заасан химийн бодис хадгалахад тавигдах үндсэн шаардлага, Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын 3.2.1.6-д заагдсан шаардлага, Химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS6458:2014 стандартыг хангасан агуулах юм.

**Төслийн байршил:** Нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт, Улаанбаатар хотын төвөөс 35 км-т зүүн уртрагийн 107° 16' 00.0", баруун өргөргийн 47° 43' 33.0" -т байрлана.

### Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол

№	Өргөрөг	Уртраг
1	47°41'20.31"N	107°12'18.12"E
2	47°41'20.44"N	107°12'18.74"E
3	47°41'19.86"N	107°12'19.14"E
4	47°41'19.62"N	107°12'18.33"E

**Зураг 1. Талбайн байршлын тойм зураг**



**Зураг 2. Химийн бодисын агуулах**



Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хими консалтинг” ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр



Алма Кем Трейд ХХК-ийн түрээсийн гэрээг хийгч “Очир Ундраа” ХХК нь Налайх дүүргийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 28- ны өдрийн А/46 тоот захирамжийг үндэслэн 15 жилийн хугацаатайгаар 0000265196 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг “Агуулах


барилга, байгууламж, бусад газар”-ын зориулалтаар авсан байна. Тус газрыг газар эзэмших эрхийн гэрчилгээнд заасан зориулалтын дагуу ашиглаж байна.

### Хүснэгт 2. Төслийн газар эзэмших эрхийн талаар мэдээлэл

Газрын мэдээлэл	Тайлбар
Газрын эзэмших эрхийн гэрчилгээний дугаар:	0000265196
Газрын захирамж:	Налайх дүүргийн Засаг даргын 2024 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/46 дугаар захирамж
Газрын зориулалт:	Агуулах барилга, байгууламж, бусад газар
Нэгж талбарын дугаар:	1261600462
Газрын хэмжээ:	21,192 м <sup>2</sup> буюу 2.12 га
Газар эзэмших эрхийн гэрчилгээний хүчинтэй хугацаа:	15 жил

Химийн бодисын агуулах нь Нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт харьяалагдана. Тус агуулахыг химийн бодисыг түр агуулж хадгалах, ачиж тээвэрлэх зориулалттайгаар ашиглах бөгөөд хүнд даацын ачаа тээврийн машин орж, төрөл бүрийн химийн бодис буулгах, ачих зориулалттай юм. Агуулахыг түрээслүүлэгч нь “Очир-Ундраа” ХХК бөгөөд “Алма Кем Трейд” ХХК –нь урт хугацаагаар түрээслэн дээрх үйл ажиллагааг явуулахаар төлөвлөөд байна.


Алма Кем Трейд” ХХК нь Европийн холбооны улсуудаас сайн чанарын химийн бодисыг худалдан авч Монгол улсын зах зээлд нийлүүлэхээр төлөвлөж байна. Түүнчлэн “Алма Кем Трейд” ХХК нь “Очир-Ундраа” ХХК-ийн химийн бодисын агуулахын “12х10 буюу 120 м.кв талбайтай Агуулах№2”-ыг урт хугацааны түрээсийн гэрээ хийж үйл ажиллагаа явуулах юм. Тиймээс нийт 13 нэр төрлийн химийн бодисыг түрээсийн 12х10м хэмжээтэй агуулахын 2-р байранд хадгалахаар төлөвлөж байгаа хэдий ч харилцагч байгууллагатай худалдаалах гэрээг үндэслэн шууд нийлүүлэхээр төлөвлөсөн.



Зураг 3. Агуулахад хадгалах бодисын төрөл

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хими консалтинг” ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Тус агуулах нь 120 мкв талбайтай бүхий химийн зориулалт бүхий агуулахад 1 сард 2 удаа таталт хийх байдлаар жилдээ нийт 2740 тн химийн бодисыг хадгалахаар төлөвлөж байна. Хэдий хадгалах агуулах хүрэлцээтэй ч, эдийн засгийн болон худалдан авагчийн хэрэгцээг тулгуурлаж химийн бодисыг агуулах руу хүргэхээс илүүтэй шууд харилцагчийн агуулах руу хүргэхээр төлөвлөж байна.



Зураг 4. Агуулахын гадна талбайн тохижилт, тэмдэг, тэмдэгжүүлсэн байдал



Зураг 5. Химийн бодис, пиротехникийн хэрэгслийн агуулахын дотор орчны харагдах байдал

### Хүснэгт 3. Химийн бодисын агуулахад хадгалагдах бодисын жагсаалт

№	Химийн бодисын монгол нэршил	Химийн бодисын бусад нэршил	CAS дугаар	Төлөв	Х.Н	Хэмжээ /Жил/
1	Метил изобутил карбинол	Метил изобутил карбинол	108-11-2	Шингэн	тн	2500
2	Полиакрилонитрил ба битум	(C <sub>3</sub> H <sub>3</sub> N) <sub>n</sub>	25014-41-9	Хуурай	тн	100
3	Adhesion Promoter Wetfix BE	Өндөр тосны хүчлүүдийн полиамин конденсат	68910-93-0	Шингэн	тн	100
4	Наалдацыг дэмжигч Diamine OLBS	N-Олейл-1,3-диаминопропан / Диэтиленгликоль	7173-62-8 111-46-6	Шингэн	тн	100
5	Дулааны хольцтой нэмэлт Rediset LQ-1200	Тосны хүчил, полиэтиленполиаминтай урвалд орсон бүтээгдэхүүн	68910-93-0 68131-73-7	Шингэн	тн	20
6	Битумын эмульгатор Redicote C-320E	Таллоу триметилпропилендиамин / Өндөр тосны хүчил, тетраэтиленпентаминтай урвалын бүтээгдэхүүн	68783-25-5 68555-22-6	Шингэн	тн	100
7	Битумын эмульгатор Redicote EM44	Олейлдиамин этоксилат	68442-23-9	Шингэн	тн	20
8	Битумын эмульгатор Redicote E-11	N,N,N',N',N'-Пентаметил-N-таллоу алкил-1,3-пропан диаммонийн хлорид / 2-Пропанол	68607-29-4 67-63-0	Шингэн	тн	100
9	Бутименийг өөрчлөх нэмэлт RWalast	Стирол-бутадиен-стирол: 30% - 40% • Битум: 40% - 60% • Тальк: 3% - 15%	9003-55-8 92062-05-0 14807-96-6	Үрэл	тн	100
10	Бутименийг өөрчлөх нэмэлт Kraton	Стирол-бутадиен-стирол полимер (SBS)	9003-55-8	Үрэл	тн	100
11	Бутименийг өөрчлөх нэмэлт LG 501S	Стирол-бутадиен-стирол полимер (SBS)	9003-55-9	Үрэл	тн	100
12	Redicote E-4875 NPF	Саармагжуулагч / Дахин боловсруулах зориулалттай эмульгатор	68412-54-4	Шингэн		20
13	Elixore 205	Эликсор 205	NA	Шингэн		100
<b>Нийт</b>						<b>3,700</b>

## **1.2. Төсөл хэрэгжих орчны газар ашиглалт, дэд бүтцийн хөгжил**

**Химийн бодис тээвэрлэлт:** “Алма Кем Трейд” ХХК нь Химийн бодисуудаа тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагааг хангахдаа дараах хууль тогтоомж, дүрэм журмыг хатуу мөрдөнө.

- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
- Химийн хорт болон аюултай бодис хадгалах тээвэрлэх, ашиглах, устгах журам
- Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм
- НҮБ-аас 2002 оны 04 сард гаргасан “Аюултай ачаа бараа тээвэрлэх зөвлөмж, зохицуулалтын заавар”
- MNS5029-2011 Химийн хорт бодисын шошго тэмдэглэгээ
- MNS4978-2000 Аюултай ачаа, ангилал, техникийн шаардлага

### **Төслөөс гарах хог хаягдал**

“Алма Кем Трейд” ХХК-ийн Химийн бодисын агуулахын төсөл нь Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “ Аюултай хог хаягдлын түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай бодогдох хууль журмыг үндэслэнэ “Цэцүүх трейд” ХХК-тай гэрээ байгуулахаар төлөвлөсөн. Тус гэрээнд Алма Кем Трейд ХХК-ийн Химийн бодисын агуулахаас гарсан Аюултай хог хаягдлыг хүлээн авч дахин боловсруулах устгалд оруулах юм.

### **Усан хангамж, хэрэглээ**

#### ***Унд ахуйн ус хэрэглээний тооцоо***

Химийн бодисны агуулах төсөлд нийт 11 хүн ажиллах ба Нэг ажилчны хоногийн усны хэрэгцээг 20\* л гэж үзвэл хоногт 220 л ус, нэг жилд /210 хоног/ 46.2 м<sup>3</sup> ус хэрэгцээтэй байна. (\* - БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 12 дугаар хавсралт –“Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”, хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон байр, ус халаагууртай, усанд орох онгоцтой орон сууц – 150 л/хоног/хүн)

Уг төсөл нь унд ахуйн усны хэрэглээндээ зөөврөөр баллонтой ус ашиглана.

### **Бусад туслах байгууламж**

“Очир-Ундраа” ХХК-ийн агуулах нь баруун, зүүн, урд талаараа 2 метрийн өндөртэй торон хашаатай бөгөөд торон хашааны гадуур 50 метрийн радиуст “Хориотой бүс” анхааруулах тэмдгийг байрлуулсан байна. Агуулахын хашаанаас 5 метрийн зайд 0.5 метрээс багагүй гүнтэй үерийн ус ба гал түймрээс хамгаалах шуудуу татсан байна. Зүүн урд талаасаа орох хаалгатай ба хаалганаас зүүн урагш 200 м газарт “Цугларах цэг” байршуулсан байна.

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хими консалтинг” ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр



**Зураг 6. Үер усны хамгаалалтын шуудуу**

#### **Харуул хамгаалалт**

Агуулахыг нийтэд нь хянах боломжтой шалган нэвтрүүлэх байр нь хашааны зүүн урд байрлах бөгөөд хамгаалалтын тусгай хэрэгсэл болон холбоогоор бүрэн хангагдсан гэрээт харуул хамгаалалтын албыг 24 цагаар ажиллана.



**Зураг 7. Харуулын байр, хашаа хамгаалалт**

#### **Аянга зайлуулагч**

Нийт 16 аянга зайлуулагчтай. Химийн бодис, пиротехникийн хэрэгслийн агуулахын зүүн тал 2 ширхэг, Аммонийн нитратын агуулахын эргэн тойронд 10 ширхэг, пиротехникийн хэрэгслийн агуулахын урд болон баруун талд 2 ширхэг, шинэ Химийн бодис, пиротехникийн хэрэгслийн агуулахын эргэн тойронд 4 ш аянга зайлуулагч байрлуулсан байна.

## 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Байгаль, цаг уур:** Налайх дүүрэг орчим жилийн агаарын дундаж температур  $-3.0^{\circ}\text{C}$ , өвлийн хүйтэн агаарын дундаж температур 1 дүгээр сард  $-20-25^{\circ}\text{C}$ , зуны дулаан агаарын дундаж температур 7 дугаар сард  $19.0-20.1^{\circ}\text{C}$  дулаан байдаг. Агаарын үнэмлэхүй бага температур  $-49^{\circ}\text{C}$  (1954 оны 2-р сард) хүрж байсан бол, үнэмлэхүй их температур  $39.5^{\circ}\text{C}$  (2005 онд) хүрч температурын агууриг  $87.6^{\circ}\text{C}$  болдог. Өвөлдөө  $-30^{\circ}\text{C}$ -аас доош хүйтрэх өдрийн тоо жилд 40 орчим, зундаа  $30^{\circ}\text{C}$ -аас дээш дулаарах өдрийн тоо 10 орчим байна.  $10^{\circ}\text{C}$ -ээс давж дулаарах өдөр хавар 5 сараас намар 8 сарын 25 хүртэл 80 орчим хоног байдаг.

### Газрын гадарга

Химийн бодисын агуулах нь Улаанбаатар хотын Тус химийн бодис, пиротехникийн хэрэгслийн агуулах нь Нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутагт дэвсгэрт Улаанбаатар хотоос 35 км, Налайх дүүргээс 5 км зайд зүүн уртрагийн  $107^{\circ} 14' 56.0''$ , баруун өргөргийн  $47^{\circ} 44' 41.0''$ -т байрлана.

Газрын гадаргын хувьд тэгш, усан сүлжээ, гуу жалга, мод сөөг байхгүй. Үйлдвэрийн орчинд хүн амын суурьшлын бүс байхгүй.

### Агаарын чанар

Төслийн талбайгаас байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад агаарын хэмжилт хийхэд агаар дахь Хүхэрлэг хий, Азотын давхар исэл, Нийт тоос нь Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2025, Хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

### Гадаргын болон Газрын доорх ус

Төслийн талбай болон түүний ойр орчимд гадаргын уст цэг байхгүй. Төслийн талбайгаас хамгийн оршиж байгаа уст цэг нь талбайн баруун талд нэр тодорхойгүй булаг 3.5 км, Туул голын цутгал гол болох Хөлийн гол 5.5 км-т, талбайн хойд талд 10 км-д Туул гол урсаж байна.

### Хөрсөн бүрхэвч

“Алма Кем Трейд” ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн талбай нь Нийслэлийн Налайх дүүргийн нутаг дэвсгэрт орших бөгөөд “Очир Ундраа” ХХК-ийн эзэмшлийн талбайд байрлана.

Хөрсний хээрийн судалгаагаар илрүүлсэн хөрсний төрлийг монгол оронд мөрдөж буй хөрсний ангилал, газрын гадаргад тархсан хөрсийг газарзүйн байршил тархалтыг харгалзан нам уулс ухаа гүвээ толгодын ангилалд хамаарна. Төсөл хэрэгжих бүс нутагт хөрсний уулын, нам уулын, ухаа-толгодын зэрэг хэв шинж тохиолддог. Хөрс газарзүйн ангиллын хувьд Хангайн хөрсний их муж, түүн дотор хангайн мужид багтана. Хангайн мужид хамгийн их тархсан түгээмэл хөрс нь хүрэн хөрс юм. Хүрэн хөрсний хар хүрэн, хүрэн, цайвар хүрэн, уулын хүрэн, нугын хүрэн, ойн хүрэн зэрэг хэд хэдэн дэд хэв шинж тархсан.

Лабораторийн шинжилгээний дүнгээс үзэхэд хүрэн хөрсний хувьд 0-15см А үе нь сул шүлтлэг урвалын орчинтой дунджаар 8.79 орчим, ялзмагийн агууламж 0.97% буюу муу, Хөдөлгөөнт суурийн ( $P_2O_5 + K_2O$ ) нийлбэр 14.7 мг/100гр, хялбар уусах давсны агууламжийн хувьд 0.009 dS/m орчим байна. 16-28 см-ийн гүний В үе нь шүлтлэг урвалын орчинтой дунджаар 8.77 ялзмагийн агууламж 0.84 %, хөдөлгөөнт суурийн ( $P_2O_5 + K_2O$ ) нийлбэр 14.4 мг/100гр, хялбар уусах давсны агууламжийн хувьд 0.10 ds/m орчим байна. (Хүснэгт 13). Хөрсний үе давхарга эхний 2 үе карбонатын агууламж 1.96-2.14% байна.

Хөрсний жижиг хэсгүүдийн бүрэлдэхүүн, хөрсний механик бүрэлдэхүүнийг Качинскийн ангилалаар тодорхойллоо. Тухайн дээжний хариунаас харахад хөрсний механик бүрэлдэхүүн 0.05-1.0 ширхгийн хэмжээ нь 68.4% байгаа тул тухайн хөрс нь хөнгөн шавранцар хөрсний ангилалд багтаж байна. Хоёр дахь үеийн лабораторийн хариу нь бүрэлдэхүүн 0.05-1.0 ширхгийн хэмжээ нь 68.9% байгаа тул тухайн хөрс нь мөн хөнгөн шавранцар хөрсний ангилалд багтаж байна.

Төслийн талбайгаас хүнд металлын дээж авч, өргөн тархалттай хүнд элементүүд болох (Pb, Cd, Zn, Ni, Cr) элементүүдийн агууламжийн магадлан итгэмжлэгдсэн “Ланд Овнер” ХХК-ийн лабораторид ICP-MS багаж ашиглан тодорхойлуулсан. Талбайн хүнд элементийн бохирдлын MNS5850:2019 харьцуулан тодорхойлоход стандартаас давсан үзүүлэлт байхгүй,

### **Ургамлан нөмрөг**

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших хаягдал тос боловсруулах үйлдвэрийн төслийн талбайн хүрээнд ургамлын судалгааг хийж гүйцэтгэхэд Улалж-алаг өвст бүлгэмдэл тархсан байна.

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хими консалтинг” ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

**Улалж-алаг өвст** үетнээс Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* C.A.Mey.), Агь (*Artemisia frigida* Willd.) зонхилж, алаг өвснөөс Ишгүй гичгэнэ (*Potentilla acaulis* L.), Амманы сэдэргэнэ (*Convolvulus Ammanii* Desr.), Замын таван салаа (*Plantago depressa* Willd.), Имт гичгэнэ (*Potentilla bifurca* L.), Божмог шарилж (*Artemisia anethifolia* Web. ex Stechm.), Ээрэм шарилж (*Artemisia macrocephala* Jacquem.), Адамсын шарилж (*Artemisia Adamsii* Bess.) зэрэг нийт 7 овог, 11 зүйл ургамал ургасан, 100м<sup>2</sup> талбайд – д 9-10 орчим зүйл тааралдаж байв.

Газрын гадаргын нийт бүрхцэд ургамлын тусгаг бүрхэц 75.2%, түүнээс талхагдлын заагуур ургамлын бүрхэц 35.3%, хайрга чулуу 8.4%, халцгай газар 16.4% байна.<sup>1</sup>

---

<sup>1</sup> БОННУ-ний нэмэлт тодотголын тайлан

### **3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ**

#### **3.1.Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ**

Химийн бодисын агуулахад хадгалагдах бодисуудыг хадгалахдаа аюулгүйн ажиллагааны дүрмийг баримтлаагүй улмаас химийн бодис ихээр алдагдсанаар агаарт дэгдэж хүний эрүүл мэндэд нөлөөлж болох ба бодис алдагдсан цаг тухайд саармагжуулах аргыг хэрэглэвээс нөлөөллийн үргэлжлэх хугацаа нь харьцангуй бага байна. Мөн хог хаягдлыг ил задгай зөвшөөрөгдсөн ангиллын дагуу бус устгаснаас нөлөөлөл үүсэж болзошгүй юм. Агаарын бохирдол нь хамрах хүрээ хязгаарлагдмал, бодис бүрийг зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу устгавал агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл бага болно.

#### **3.2.Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл**

Агуулахын талбай нь бүхэлдээ хатуу хучилт бүхий учир алдагдсан химийн бодис газрын доорх усанд нэвчих хурд бага юм. Иймд нөлөөллийн эрчим бага хэрвээ газрын доорх усанд алдагдах нөхцөлд удаан хугацаанд хадгалагдах магадлалтай юм.

-Хортой, аюултай бодисын хадгалалт, устгалын шаардлага хангаагүйгээс хортой, аюултай химийн бодис, эсвэл хоорондоо үл нийцэх бодисууд нэгдэж болзошгүй аюул бий болох, ашигласан бодисуудын хаягдлыг устгалын шаардлага хангахгүйгээр шууд хаяснаар усан орчинд шууд болон дам нөлөө үзүүлэх

-Технологийн хэрэглээний явцад хэрэглэсэн бодисыг саармагжуулж, хоргүйжүүлээгүйгээс хортой нэгдэл үүсэх, хорын тархалт бий болох

#### **3.3.Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл**

-Тээвэрлэлт, түгээх, хүлээн авах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг хөрсөнд алдаж, түүний найрлага бүтцийг өөрчлөх,

-Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдсанаар ургамалжилт, гадаргын болон газар доорх ус, ургамал амьтанд дам нөлөөлөл үзүүлэх зэрэг болно,

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хими консалтинг” ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

-Тээврийн хэрэгслийн тоо нэмэгдэх нь тухайн бүсийн хөрсний бохирдол өсөх, бохирдуулагч бодисын хуримтлал үүсэх нөхцөлийг бий болгох бөгөөд ингэснээр, хөрсөн дэх техноген бохирдуулагч бодисын хэмжээ нэмэгдэх

-Автомашин утаанаас гарах хар тугалга зэрэг хорт бодис нь зам орчмын хөрсөнд, хүний эрүүл мэндэд муугаар нөлөөлөх

-Хадгалалтын шаардлага хангаагүй бодисын химийн нэгдэл хур борооны болон чийг авснаас урсаж хөрс бохирдуулах нэвчих хурд бага юм. Иймд нөлөөллийн эрчим бага бөгөөд хэрвээ газрын доорх усанд алдагдах нөхцөлд удаан хугацаанд хадгалагдах магадлалтай юм.

#### **4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Засгийн газар, БОАЖЯ болон бусад холбогдох газруудаас гаргасан зохих заавар, журмын дагуу Алма Кем Трейд ХХК-ийн “Химийн бодисын агуулахын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хими консалтинг” ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

**Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	9
1	<p><b>Агаарын чанар</b></p> <p>Химийн бодис, бүтээгдэхүүний хаягдлын тоосжилт, ууршилт бүхий хэсгүүд салхиар дамжин хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй. Агуулахад хадгалагдаж буй шингэн, хуурай нунтаг химийн бүтээгдэхүүн болон бодисуудын уур, тоос салхиар дамжин агаарт дэгдэх</p>	Химийн бодис тээвэрлэж буй машин, техникийн засвар үйлчилгээг тогтмол хийж хорт хий ялгаруулалтад хяналт тавьж багасгах арга хэмжээг авах	Төсөлд ашиглагдах тоног төхөөрөмж	Мот/цаг	100 000	Төслийн хугацаанд	<ul style="list-style-type: none"> <li>- Агаарын тухай хууль</li> <li>- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль</li> <li>- MNS 4585:2016</li> <li>MNS 3384:82</li> </ul>
		Талбайн гадна болон агуулах дотор рчны агаарын бохирдлын байдалд шинжилгээ хийлгэх	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан			2026 он	
		Бодис хадгалах тавиур хийж шаардлага хангахуйц бэхлэн тогтоох	Химийн бодисын агуулах	-	500 000	2026 он	
		Галын хор, гал унтраах хэрэгслээр хангах	Химийн бодисын агуулах	-	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардалд орсон	2026 он	
	<b>Нийт</b>				<b>600 000</b>		
2.		Ус ашиглах гэрээгээ байгуулан төлбөрөө төлнө			1000000	2026 он	Усны тухай хууль MNS 900:2005

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хими консалтинг” ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

	<b>Гадаргын ба газрын доорх усны нооц</b>	Газрын доорх усны бохирдлыг хянах зорилгоор хяналт мониторингийн цооног байгуулах	Үйлдвэрийн хашаанд цооног байгуулсан байгаа		2026 он	MNS 4943:2015 MNS 5850:2008	
		Ус хангамжийн худгийн усны түвшний бууралт, горим, чанарын өөрчлөлтийг байнга хянах зорилгоор усны чанарын шинжилгээг хийж үр дүнг хянаж ажиллах	Уст цэгт	Зардал нь хяналт шинжилгээний зардалд орсон		2026 он	
<b>Нийт</b>		<b>1 000 000</b>					
<b>3.</b>	<b>Газрын хэвлий болон Хөрсөн бүрхэвч</b> Химийн бодисыг импортлох, ашиглах, хадгалахад санамсаргүй алдагдал, ахуйн хог хаягдлыг зориулалтын цэгт төвлөрүүлж графикт хугацаанд ачиж зайлуулахгүй байх зэрэг нь хөрсний бохирдолтыг бий болгоно. Хүн, машины хөдөлгөөний улмаас агуулахын	Агуулахын орчны зам талбайг гүйцээн хатуу хучилттай болгох	Төслийн талбайн хэмжээнд	-	1 500 000	2026 он	MNS 5916:2008 MNS 5917:2008
		Химийн бодисын хаягдал ашиглалтын шаардлага хангахгүй болсон химийн бодисыг зайлуулах, устгах хүртэл түр хуримтлуулах, хадгалах зориулалтын сав талбайг зохих шаардлагын дагуу салхины ноёлох чиглэлийн доор байрлуулах	Засварын талбай, авто зогсоол	-	700 000	2026 он	MNS 5918:2008
		Төслийн талбайгаас авсан хөрсний дээжид хүнд металлын бохирдол хэдий илрээгүй ч цаашид тогтмол “Хөрс бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850:2019 стандартад заасан хүлцэх хэмжээнд байгаа эсэхийг	Үйлдвэрийн талбай	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан			



Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хими консалтинг” ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

		ургуулах, харь зүйлийн ургамлын үр, суулгац суулгахаас татгалзах		арилгах арга хэмжээнд тусгагдсан		
	<b>Нийт</b>		<b>1 000 000</b>			
<b>5</b>	<b>Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал 3 800 000</b>					

## 5. НОГООН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТЭРБУМ МОД ХӨТӨЛБӨР


“Алма Кем Трейд” ХХК нь 2026 онд тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Налайх дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Тэрэлжийн зам дагуух нийтийн эзэмшлийн талбайд 100 мод тарихаар төлөвлөв. Мод тарих үйл ажиллагааг Монгол Улсын ерөнхийлөгчийн 2010оны 4-р сарын 14-ний өдрийн дугаар 63 тоот зарлигаар баталсан жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дугаар долоо хоногийн “Бямба гарагийг бүх нийтээрээ мод тарих өдөр болгон зарлиг гаргасны дагуу 5, 10-р сард байгууллагын ажилчдаараа ногоон байгууламжаа тарина.

### Хүснэгт 5. Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө

№	Ногоон байгууламж байгуулах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд	100 ш мод тарина	-	100 ш	-	1200000	2026 онд	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
2	Агуулахын хажуу хэсэгт болон явган зам дагуу	Ногоон байгууламж байгуулах		1000 м.кв		1 000 000	2026 онд	MNS 6263: 2011 MNS 5994: 2009 MNS6253-2: 2011 MNS 5918: 2008
	Нийт					2 200 000		

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хими консалтинг” ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

**Зураг 8. Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд мод тарих газрын байршил, 2026 он**



Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хими консалтинг” ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

## 6. ХИМИЙН БОДИС ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2	Химийн бодистой харьцаж буй ажилчид гэмтэж бэртэх	Ажилчдыг хөдөлмөр хамгаалалтын хэрэгслээр хангаж ажиллах	Бүх ажилчид		Үйл ажиллагааны зардалд орно.	
3	Гал түймэр гарах	Гал унтраах хэрэгсэл, галын дохиолол, аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материал, хувийн хамгаалах хэрэгслийг шаардлагатай газар байрлуулж, сольж цэнэглэж ашиглалтын бэлэн байдлыг хангасан байх		Иж бүрэн	700.0	Галаас хамгаалах тухай хууль
4	Ажилчдын хайхрамжгүй үйлдлээс болж химийн бодис асгарч, алдагдах	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалт явуулах	Химич, жолооч, бусад химийн бодистой харьцах ажилчид		300.0	ХААБ зааварчилгаа
5	Химийн бодисыг хадгалах, ашиглах үед үүсэх эрсдэл	Үйлдвэрт ашиглагдах химийн бодисын хор аюулын лавлахыг шаардлагатай газруудад мэдээллийг нүдэнд харагдахуйц газар байрлуулсан байна	Үйлдвэр, химийн бодисын агуулах, лаборатори		500.0	
6	Эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Химийн бодис хадгалах үйл ажиллагаа эрхлэгч нь ажилтнуудыг жилд нэг удаа эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.			Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардалд орсон	
7	Химийн бодисыг хадгалах, ашиглах үед үүсэх эрсдэл	Химийн бодисын бүртгэлийн дэвтэртэй болох			50	
8	Химийн бодисыг хадгалах, ашиглах үед үүсэх эрсдэл	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд худалдан авч байршуулах			500.0	
	Нийт				2 150.0	

## 7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, үйлдвэрийн ажилчдын хэрэгцээнээс хаягдах бохир ус, химийн бодисын сав баглаа боодол зэргээс бүрдэж байна.

Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

### Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хог Хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлыг дүүргийн ТҮК-тэй гэрээ байгуулан зөөвөрлөх	Налайх дүүргийн нэгдсэн хогийн цэгт хогоо нийлүүлэх,	кг	-	-	Үйлдвэрийн дотоод зардалд орсон.	Хог хаягдлын тухай хууль
		Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах ялгах хогийн сав авч байршуулах	Ажилчдын байрны гадна байршуулах	тоо	200 000	3	600 000	
2	Аюултай хог хаягдал	Химийн бодисын сав баглаа боодлыг химийн хортой, аюултай бодис устгах, тээвэрлэх, дахин боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгуулалтай гэрээ байгуулж устгах	Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэнд	тоо	400 000	-	400 000	
Нийт зардал					1 000 000			

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хими консалтинг” ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

## 8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2	Ажилчид гэмтэж бэртэх	Ажилчдыг хөдөлмөр хамгаалалтын хэрэгслээр хангаж ажиллах	Бүх ажилчид		Үйл ажиллагааны зардалд орно.	
3	Гал түймэр гарах	Гал унтраах хэрэгсэл, галын дохиолол, аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материал, хувийн хамгаалах хэрэгслийг шаардлагатай газар байрлуулж, сольж цэнэглэж ашиглалтын бэлэн байдлыг хангасан байх		Иж бүрэн	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд орсон	Галаас хамгаалах тухай хууль
4	Ажилчдын хайхрамжгүй үйлдлээс болж осол гарах	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалт явуулах	Бүх ажилчид		300.0	ХААБ зааварчилгаа
5	шаардлагатай газруудад мэдээллийг нүдэнд харагдахуйц газар байрлуулсан байна	гал унтраах хэрэгсэл, галын дохиолол, аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материалын байрлалыг заасан зураг, схем; аюултай хог хаягдал хариуцсан ажилтны овог нэр, утасны дугаартай самбар	Төслийн талбайд		Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд орсон	
6	Эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Химийн бодистой харьцаж үйл ажиллагаа эрхлэгч нь ажилтнуудыг жилд нэг удаа эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.			1000.0	
	Нийт				1300.0	

## 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь Налайх дүүргийн нутагт хэрэгжиж буй Химийн бодисын агуулах төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон түүний үйл ажиллагааны явцад гарч болзошгүй эрсдэлийн үед байгаль орчинд бий болох бохирдол, доройтлыг тодорхойлох зорилготой заавал хэрэгжүүлэх баримт бичиг юм.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж үр дүнг нь доорх асуудлуудыг тодорхойлох, үнэлэхэд ашиглана. Үүнд:

- Анх таамагласан сөрөг нөлөөллүүдийн хэмжээ, үр дагавраас бодит сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар хир зөрж байгааг
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт болон холбогдох эрх зүйн баримт бичиг, стандарт, дүрэм журамтай нийцэж байгаа эсэхийг
- Нөлөөллүүдийн эрчим, буурах эсвэл нэмэгдэж байгаа
- Төслийн БОМТ-ний нийт үр ашгийг үнэлэх зэрэг орно.

**Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр**

Хяналт шинж	Хэмжих нэгж	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар	Тоосонцор: TSP, PM2.5, PM10	Улиралд нэг удаа. Шаардлагатай тохиолдолд тухай бүрт нь.	-	-	MNS 4585:2016 MNS 6063:2010 MNS 5002:2000 MNS 3113:1981 MNS 5885:2008 Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
	SO <sub>x</sub> NO <sub>x</sub> CO <sub>x</sub>		50	250.0	
	Дуу чимээ Агаарын температур Харьцангуй чийглэг Агаарын урсгалын хурд Гэрэлтүүлэг, БГК,		200	800.0	
	Нийт зардал			1050.0	
Хөрсөн бүрхэвч	- Механик бүрэлдэхүүн - Хими, физикийн шинж чанар - Бохирдол - Хүнд металл /Pb, Cd, Hg, As, Cr,.../ - Бактереологи	4 удаа	100	400.0	MNS 5850 : 2008 MNS 3298 : 1991 MNS 5546 : 2005 MNS 3985 – 87 MNS 2305 - 94
	Нийт зардал			400.0	
Ажиллагсдын эрүүл мэндийн	- Мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвтэй гэрээ байгуулж ажиллана.	Жил бүр Шаардлагатай тохиолдолд тухай бүрт нь.	хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хөтөлбөрт тусгагдсан.		Ажлын байрны нөхцөл, эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл болон аюулгүй ажиллагааны талаар баримталдаг Монгол улсын стандартууд
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>				<b>1450.0</b>	

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хими консалтинг” ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Зураг 9. Мониторингийн байршлын зураг



## 10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавьж ажиллана.

**Хүснэгт 8. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал**

Болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Ажилчдын мэдлэг чадвар дутмаг байдлаас ажлын доголдол гарах	БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан үйл ажиллагааг зохион байгуулах, дотоод журам тогтоож мөрдөх	Ажилчид	Дотоод зохион байгуулалтаар	Жил бүр	МУ-ын үндсэн хууль Хөдөлмөрийн тухай Эрүүл мэндийн тухай Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм MNS 4990:2000 MNS 4968:2000 MNS 4994:2000
ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах		Дотоод зохион байгуулалтаар			
Химийн бодисын нэр төрөлд нэмэлт өөрчлөлт орох бүрд дахин байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэмэлт тодотгол хийлгэх шаардлагатай		Бүх ажилчдыг	Үйл ажиллагааны зардалд орсон	Өдөр бүр	
Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах					
Нийт			-		

## 11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ

### Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх арга хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Төслийн талбайн ойролцоох иргэд болон төсөл хэрэгжиж буй дүүрэг, сонирхогч талууд, засаг захиргааны ажилчид	Төслийн талаарх мэдээллийг цаасан болон presentation хэлбэрээр тайлагнах, хэлэлцэх	Төслийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, төслөөс байгаль орчин болон нийгэм эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлсэн эерэг, сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах багасгах чиглэлээр хийсэн арга хэмжээ, байгаль хамгаалах, ногоон байгууламж, мод тарьсан ажлын тухай	Жилд 1 удаа. 10-11 сард.	Төслийн үйл ажиллагаагаар ойролцоох иргэд амьдрал ахуй, эрүүл мэнд, нийгэмд үзүүлсэн эерэг, сөрөг нөлөө, сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах чиглэлээр хэрэгжүүлбэл зохистой арга хэмжээ, төслийн үйл ажиллагааны талаарх санал бодлыг сонсох	Дүүрэг эсвэл хороонд
Зардал, мян.төг					500000

БОМТ-ний биелэлтийн тайланг тухайн оны 12 сарын 10-ний дотор БОАЖЯаманд ирүүлэх ба үүнээс өмнө хуваарийн дагуу орон нутгийн иргэд, засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчид, сонирхогч талуудад танилцуулж хэлэлцүүлэн тэдний санал бодлыг тайланд тусгасан байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв

**Хүснэгт 10. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт**

Д.д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	3800.0
2	Тэр бум мод ажлын зардал	2200.0
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1000.0
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1450.0
5	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2 150.0
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1300.0
7	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	-
8	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах	500.0
<b>2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн</b>		<b>12 400.0</b>

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө нөхөн сэргээх арга хэмжээнд нийт **12.4 сая** төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Үүний 50 хувь 6.2 сая төгрөг байна. Бид Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулсан.